



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/01/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2024 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
5. Аудитын илрүүлэлт	7
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 123

төрийн _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төвлөрсөн халаалтад холбогдсон орон сууцанд амьдардаг 10 албан хаагчид түлээ, нүүрс худалдан авахад зориулж 4.0 сая төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон.
2. ИТХ нь хөдөлмөрийн гэрээгээр ажилласан албан хаагч нарт 6.8 сая төгрөгийн цалин хөлсний зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас шийдвэрлэж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.
3. Байгаль хамгаалах сан нь санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 31.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
4. Орон нутгийн хөгжлийн сангаас иргэнд 23.2 сая төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал олгосон.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай" журмын 4 дүгээр зүйлийн 4.7.6-д заасан заалтуудтай нийцэхгүй, нийцсэн байх мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшинээс 3.3 дахин их, зардлыг зориулалт бус зарцуулсан, санхүүгийн тайлан дахь өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь шинж чанар, агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны эхнээс орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн, ахмадын сангийн үлдэгдлийг тухайн төсвийн байгууллагын хөтөлбөр арга хэмжээ болгон тайлагнадаг болсон. Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын 2023 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 15.6 хувиар буюу 64.5 сая төгрөгөөр давсан боловч 79.6 сая төгрөгөөр 6 нэр төрлийн татварын орлого тасарч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 141 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 136 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 80.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,218,239.3	1,333,743.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,000,148.4	916,866.2
33	АВЛАГА	69,655.3	205,933.3
35	БАРАА МАТЕРИАЛ	148,435.6	210,943.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,806,216.2	4,365,661.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,806,216.2	4,365,661.3
39200	Биет хөрөнгө	3,638,427.8	4,191,445.6
39300	Биет бус хөрөнгө	167,788.4	174,215.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,024,455.5	5,699,404.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,597.3	42,307.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,597.3	42,307.4
41300	Өглөг	40,597.3	42,307.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,983,858.2	5,657,097.2
51	Засгийн газрын хувь оролцоо	4,983,858.2	5,657,097.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	895,186.8	895,186.8
51200	Хуримтлагдсан үр дүн	4,088,623.0	4,761,862.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48.4	48.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,024,455.5	5,699,404.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,839,591.9	2,787,981.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	410,809.9	450,405.7
110	Орлогын албан татвар	138,708.2	156,992.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,708.2	156,992.8
113	Хөрөнгийн албан татвар	120,489.9	123,134.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	151,611.8	170,278.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	329,440.1	997,222.4
120	Нийтлэг татварын бус орлого	329,440.1	997,222.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,099,341.9	1,340,353.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,250,305.2	1,334,247.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,250,305.2	1,334,247.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,936.0	1,047,275.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,370.3	348,317.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,041.0	42,533.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,724.2	43,801.0
2104	Хангамж, бараа материалын зардал	95,985.2	63,429.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	7,151.3
2107	Томилолт, зочны зардал	10,680.0	13,644.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,105.3	8,595.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	466,030.0	519,803.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	348,369.2	286,973.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	589,286.7	1,453,733.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,140,468.2	780,119.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-3,551,181.5	673,614.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,639,782.3	8,639,782.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-104,742.6	-104,742.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,535,039.7	8,535,039.7
9	Тайлант үеийн үр дүн	-3,551,181.5	-3,551,181.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,983,858.2	4,983,858.2

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,983,858.2	4,983,858.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-375.5	-375.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,983,482.7	4,983,482.7
19	Тайлант үеийн үр дүн	673,614.5	673,614.5
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	5,657,097.2	5,657,097.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,758,744.4	1,982,071.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	410,809.9	450,405.7
110	Орлогын албан татвар	138,708.2	156,992.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,708.2	156,992.8
113	Хөрөнгийн албан татвар	120,489.9	123,134.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	151,611.8	170,278.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,240.5	3,277.3
1181	Газрын төлбөр	31,688.4	167,001.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	110,682.8	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	257,327.9	196,923.0
120	Нийтлэг татварын бус орлого	257,327.9	196,923.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,090,606.6	1,334,742.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	906,909.7	1,181,579.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,909.7	1,181,579.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	806,031.4	1,143,679.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,772.6	347,966.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,250.4	41,783.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,379.9	40,625.9
2104	Хангамж, бараа материалын зардал	41,974.0	40,660.5
2105	Нормативт зардал	0.0	2,579.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,714.4	12,032.5
2107	Томилот, зочны зардал	10,680.0	13,644.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,105.3	262,492.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,154.8	381,894.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,878.4	37,900.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	851,834.7	800,492.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	493,610.2	802,274.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	493,610.2	802,274.3
2200	Догоод эх үүсвэрээр	493,610.2	802,274.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-493,610.2	-802,274.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,360.0	-81,500.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,360.0	81,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	307,864.5	-83,282.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	692,283.9	1,000,148.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,000,148.4	916,866.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,782,926.0	1,964,399.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,240,662.9	1,103,573.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,112.9	1,088,009.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,461.5	347,966.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,255.0	41,783.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,344.8	266,437.9
2104	Хангамж, бараа материалын зардал	49,123.7	37,569.0
2105	Нормативт зардал	2,650.0	2,579.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,074.8	44,597.5
2107	Томилот, зочны зардал	13,335.0	13,104.0

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,852.5	2,838.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	410,015.6	331,133.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,550.0	15,564.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,550.0	15,564.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,383,979.5	779,326.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	158,283.6	81,500.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,782,926.0	1,792,174.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	644,846.7	644,846.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,103,677.3	988,929.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,034,402.0	158,398.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	850,061.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	677,836.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,583.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,583.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,617.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,235.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,091.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,932.5
2107	Томилолт, зочны зардал	540.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,056.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,761.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,965.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,965.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,583.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,583.5

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 79,587.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 79,587.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1.1 Албан шаардлага

Аудитаар Өлзийт сумын орон нутгийн татварын 11 нэр төрлийн орлогыг төвлөрүүлэхээс 6 нэр төрлийн 79,587.6 мянган төгрөгийн төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т /Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрг хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 560,120.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 109,636.1 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 2,896.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 447,588.3 мянган төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 80.4 хувийг залруулагдаагүй, 19.6 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Дүгнэлтийн үндэслэл, тайлбар

Нийт 450,484.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 85.2 хувь буюу 384,240.5 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 14.8 хувь нь 66,243.7 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ. Мөн Сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангаар илэрсэн 79,587.6 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 66,243.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 46,230.0 мянган төгрөгөөр буюу 3.3 дахин их байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	4	16,598.8	2	12,778.5	2	3,820.3	4	16,598.8				
ХХС	1	11,797.4			1	11,797.4	1	11,797.4				
БХС	2	81,240.0			2	81,240.0	2	81,240.0				
Дүн	7	109,636.1	2	12,778	5	96,857.6	7	109,636.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	4,308.9	1	162.2	2	4,146.7						
ИТХ	1	6,898.5			1	6,898.5						
БХС	1	31,800.0			1	31,800.0						
ОНХС	1	23,236.3			1	23,236.3						
Нийт дүн	5	66,243.7	1.0	162.2	5	66,081.4	-	-		-		-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ЗДТГ	2								2			
ИХТ	1						1					
Дүн	3						1		2			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	900.0	1	900.0								
ИТХ	1						1					

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

ОНХС	1	381,256.9			1	381,256.9						
ХХС	1	1,834.3	1	1,834.3				-				
МХС	1	250.0			1	250.0						
ТТЗ	1	79,587.6			1	79,587.6						
Дүн	6	463,828.8	2.0	2,734.3	4	461,094.5	-	-				
Нийт дүн	9	463,828.8	2.0	2,734.3	5	461,094.5	0	-	2	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1		1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	4		4					
4	ТТЗ		1						
5	ТЕЗ						1		
	НИЙТ	7	2	5		1	1		